

## “ХЭНТИЙ АЙМГИЙН ОНЫ ШИЛДЭГ АЖИЛТАН, БАЙГУУЛЛАГА”-ЫГ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Хэнтийн аймгийн оны шилдэг ажилтан, байгууллага”-аар шалгаруулахаар нэр дэвшүүлэх, тодорхойлох, түүнийг хүлээн авч судлах шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Оны шилдэг ажилтан шалгаруулах болзол

#### 2.1. Төрийн захиргааны байгууллагын шилдэг ажилтан

Хэнтий нутгийн хөгжлийн төлөө өөрийн эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гарган төрийн үйл хэргийг иргэд, аж ахуй нэгжид түргэн шуурхай хүргэх, ажлын бүтээмжийг үе шаттай сайжруулахад идэвх санаачлагатай ажилласан

#### 2.2. Хууль хяналтын байгууллагын шилдэг ажилтан

Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн болон техникийн осолын хор нөлөөг арилгахад гардан ажилласан, онц хүнд гэмт хэрэг илрүүлсэн, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоосон хуулийн хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулхад идэвх санаачлагатай ажилласан албан хаагчид.

#### 2.3. Соёл, спорт, хэвлэл мэдээллийн салбарын шилдэг ажилтан

Хэвлэл мэдээллийн салбарт шинийг хийж санаачлан, олон нийтийн талархал хүлээсэн нэвтрүүлэг, зохиомж, олон нийтийн сүлжээгээр орон нутгаа өөрийн болон гадаад улс оронд сурталчилан таниулах баримтад кино хийсэн, хүүхэд, залуучуудын мэдлэг мэдээллийг хөгжүүлэх нэвтрүүлэг бэлтгэсэн, цаг үеийн мэдээ, мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэхэд онцгой амжилт гаргасан хэвлэл мэдээллийн салбарын ажилтан байна.

#### 2.4. Санхүү, банкны салбарын шилдэг ажилтан

Санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн чиглэлээр аймгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэхүйц үр ашигтай үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлсэн, байгууллагынхаа эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулахад онцгой амжилт гаргасан.

#### 2.5. Үйлчилгээний салбарын шилдэг ажилтан

Хот тохижилт, шугам сүлжээний ажлыг арчлан хамгаалах, орон нутгийн төсөвт газрын тав тух, эрүүл тохилог орчинг бүрдүүлэх, үйлчилгээний стандартыг сайжруулахад онцгой амжилт гарган ажилласан байх

#### 2.6. Хөдөө аж ахуй, бизнесийн салбарын шилдэг ажилтан

Аймаг орон нутгийн хөдөө аж ахуй салбар, газар тариалангийн салбарт өөрийн мэдлэг, туршлага, оюун ухаанаа харамгүй зориулж, олон зүйлийг шинээр санаачлан хийж нэг га гаас авах үр тарианы гарцыг нэмэгдүүлж, үр ашгыг бодитойгоор нэмэгдүүлсэн байх, бизнесийн салбарыг хөгжүүлэхийн зэрэгцээ орон нутагийн бүтээн байгуулалтанд бодитой хувь нэмэр оруулсан байх, малын үйлдвэр угсааг сайжруулах

#### 2.7. Эрүүл мэндийн салбарын шилдэг ажилтан

Эрүүл мэндийн салбарын хэмжээний тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой төсөл, хөтөлбөр, эрдэм шинжилгээний бүтээл боловсруулж

түүнийг гардан хэрэгжүүлж эмчилгээний бодитой үр дүнд хүрсэн, эрүүл мэндийн салбарын ажилтан. Улс, тив, дэлхийн спортын уралдаан тэмцээнд, амжилттай оролцон медальт байранд шалгарсан тамирчид

#### **2.8. Боловсролын салбарын шилдэг ажилтан**

Боловсролын салбарт өөрийн мэдлэг, туршлага, оюун ухаанаа харамгүй зориулж хамт олноо удирдан зохион байгуулж сурагчдын суралцах идэвх, авъяас чадварыг нээн хөгжүүлэх, сурах орчинг сайжруулахад онцгой амжилтуудыг гаргасан боловсролын салбарын ажилтан, Урлаг, соёлын гарамгай бүтээл туурвисан онгой амжилт гаргасан уран бүтээлчид

### **Гурав. Оны шилдэг байгууллага шалгаруулах болзол**

#### **3.1. Төрийн шилдэг байгууллага**

Төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүртээмжтэйгээр нийгэмд хүргэхэд онцгой амжилт гаргаж үр дүнтэй ажилласан, шинийг санаачлан зохион байгуулсан төрийн байгууллага.

#### **3.2. Хувийн хэвшлийн шилдэг байгууллага**

Төр захиргааны байгууллагын бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангахад хамтран ажиллаж, аймаг орон нутгийн бүтээн байгуулалт, эдийн засагт онцгой сайн нөлөө үзүүлсэн, нийгэмд тустай үйл хийсэн хувийн хэвшлийн болон ТББайгууллага байна.

### **Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох**

4.1. Шагналд нэр дэвшигдэж байгаа этгээд нь энэ журамд заасан болзлыг бүрэн хангасан байна.

4.2. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтнуудыг нэр дэвшүүлэхдээ тухайн сумын Засаг дарга тодорхойлж, аймгийн Засаг даргад өргөн мэдүүлнэ.

4.2. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагийн ажилтнуудыг тухайн агентлагийн /байгууллагын/ дарга тодорхойлж, аймгийн Засаг даргад өргөн мэдүүлнэ.

4.3. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг шагналд тодорхойлохдоо байг уулагдсанаас хойших ажлын үзүүлэлт, энэ онд хийсэн онцлох ажил, гүйцэтгэлийг тусгах

### **Тав. Шагналд тодорхойлоход бүрдүүлэх материал**

5.1. Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ:

5.1.1. Энэ журмын хоёрдугаар хавсаргалтаар батлагдсан загварын анкет /гэрэл зураг 3x4 хэмжээтэй/

5.1.2. Хамт олны хурлын тэмдэглэл;

5.1.3. Ажил байдлын тодорхойлолт;

5.1.4. Шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй албан бичиг;

5.1.5. Салбартаа онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг

5.1.6. Байгууллагын хувьд А4 хэмжээтэй хамт олны зургийг хавсаргасан байх

5.1.7. Шагналд нэр дэвшсэн хүний ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын амжилт, авъяас чадвар, оруулсан хувь нэмрийг товч, тодорхой бичсэн байх бөгөөд холбогдох баримтыг хавсаргасан байна.

### **Зургаа. Шагналыг шийдвэрлэх**

6.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн холбогдох байгууллагаас шагнуулахаар нэр дэвшигдсэн хүмүүсийн материалыг файлаар болон цаасаар жил болгоны 12 дугаар сарын 18-ны

дотор хүлээн авч хянана.

6.2. Шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн нь энэ журмын дагуу материалаа бүрдүүлж ирүүлсэн иргэдийн талаар санал боловсруулан аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулна.

6.3. Шагнах асуудлыг аймгийн Засаг дарга захирамж гаргаж шийдвэрлэнэ.

6.4. Оны шилдэг ажилтанг батламж 100000/нэг зуун мянган/ төгрөгөөр, оны шилдэг байгууллагыг батламж 500000/таван зуун мянган/ төгрөгөөр тус тус шагнана.

6.5. Шилдэг ажилтан, байгууллагаар шалгарсан хувь хүн, байгууллагад урьдчилан мэдэгдэж аймгийн төв шинэ жилийн арга хэмжээн дээр шагналыг гардуулан өгнө.

Хэнтий аймгийн .....салбарын  
оны шилдэг ажилтан номинацид нэр дэвшигчийн анкет

1. Овог.
2. Нэр.
3. Төрсөн он сар
4. Хүйс:
5. Төрсөн аймаг, сум, хот :
6. Одоогийн харъяалал:
7. Нийгмийн байдал:
8. Регистр:
9. Боловсрол:
10. Ажилладаг салбар:
11. Мэргэжил :
12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

Д.д	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1			
2			

13. Урьд нь тагнагдаж байсан тагнуулууд:

	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		

14. Шагнуулах үндэслэл: Үндэслэлийг 3-4 өгүүлбэрт багтаан тодорхой оновчтой бичнэ

15. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

16. Хамт олны саналын хувь:



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 4/582

Хэрлэн сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид шагналыг урамшил олгох журам", 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймаг нийслэлийн Засаг даргаас олгох шагналын нийтлэг тодорхойлолт"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

Нэг Хэнтий аймгийн "Оны шилдэг ажилтан, байгууллага"-ыг шалгаруулах журмыг нэгдүгээр шагналд нэр дэвшүүлэх анкетын маягтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, сумдын Засаг дарга, хуулийн этгээдийн дарга, эрхлэгч, захирал, үйлчилгээний байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

Гурав Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Ганболдид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ОЮУНБААТАР